



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар А/317

Булган

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 /а/, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5, 4.1.6, 4.1.7, 4.1.8, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5.2, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийг зарцуулах журам”-ын 2.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган, Бугат, Сайхан сумын шүлхий өвчин гарсан голомтын бүсийн үхэрт халдварлалтын түвшин тогтоох ба шүлхийн эсрэг бие илрүүлэх тандалт шинжилгээ, оношлогоо хийхэд шаардагдах 17 850 000 /арван долоон сая найман зуун тавин мянга/ төгрөгийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хавсралтаар баталсан хөрөнгийн 5 450 000 /таван сая дөрвөн зуун тавин мянга/ төгрөгийг аймгийн Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх зардлаас, 1 022 000 /нэг сая хорин хоёр мянга/ төгрөгийг Засаг даргын тамгын газраас, 11 378 000 /арван нэгэн сая гурван зуун далан найман мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

3. Халдварлалтын түвшин тогтоох ба шүлхийн эсрэг бие илрүүлэх тандалт шинжилгээ, оношлогоо хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ч.Амгалан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

423

Аймгийн Засаг даргын 2018 оны
05 дугаар сарын 22-ны өдрийн А/317
тоот захирамжийн нэгдүгээр хавсралт

**ШҮЛХИЙД ӨРТСӨН МАЛД ТАНДАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ОНОШЛОГОО ХИЙХЭД ШААРДАГДАХ ЗАРДАЛ**

№	Материалын нэр	Дээж /тоо, хэмжээ, цомог	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Шүлхийн вирусын Бүтцийн бус уургийн эсрэг бие илрүүлэх урвалын оношлуурын зардал	6	2400 000	14 400 000
2	Бүтцийн бус уургийн урвалын шинжилгээний хэрэглэгдэхүүн, шинжилгээ хийх зардал	1	3 450 000	3 450 000
	Дүн			17 850 000